

M
MOTT
MACDONALD



Sainshand Salkhin
Park LLC

САЙНШАНД САЛХИН ПАРК ТӨСӨЛ ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ



Дорноговь
2017 оны 2-р сарын 14

Мотт МакДоналд
Виктори байшин
Трафалгар Плаза
Брингтон BN1 4FY
Их Британи

Утас: +44 (0)1273 365000
Факс: +44 (0)1273 365100
mottmac.com

ТЕХНИКИЙН БУС ХУРААНГУЙ

Сайншанд салхин парк

2017 оны 2-р сарын 14

Mott MacDonald Limited.
Registered in England and Wales no. 1243967.
Registered office: Mott MacDonald House, 8-10 Sydenham Road, Croydon CR0 2EE,
United Kingdom

Нэмэлт өөрчлөлтийн мэдээлэл

Өөрчлөлт	Огноо	Бичсэн	Шалгасан	Баталсан	Тайлбар
A	2017-02-10	P. Gouws L. Stone	L. Stone	I. Scott	Эхний хувилбар
B	2017-02-13	I. Bray	L. Stone	I. Scott	Бүхэл засвар
C	2017-02-15	L. Stone	L. Stone		Бага зэргийн нэмэлт
D	2017-02-16	L. Stone	L. Stone		Бага зэргийн өөрчлөлт

Бичиг баримтын дугаар:

Мэдээллийн ангилал:

Ердийн

АГУУЛГА

1	Удиртгал.....	5
1.1	Төсөл гэж юу вэ?	5
1.2	Төслийг хэрэгжүүлэгч нь хэн бэ?	5
1.3	Төсөл хаана хэрэгжих вэ?.....	5
1.4	СЦҮ болон бусад материалыг хэрхэн тээвэрлэх вэ?	7
1.5	СЦҮ нь эрчим хүчийг хэрхэн гаргадаг вэ?	7
2	Төслийн үндэслэл.....	8
2.1	Энэ төсөл яагаад хэрэгтэй вэ?	8
2.2	Төслийн ашиг тус оюунд орших вэ?	8
2.3	Ямар хувилбарууд байж болох вэ?.....	8
2.4	Байгаль орчин-нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэж юу вэ?	9
2.5	Зөвлөгөөн ба мэдээлэл түгээлт	9
2.6	Төслийн талбайн байгаль орчин-нийгмийн өнөөгийн төрх байдал	9
3	Төслийн байгаль орчин-нийгмийн болзошгүй эерэг ба сөрөг нөлөөлөл	11
3.1	Ерөнхий мэдээлэл.....	11
3.2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрхэн хэрэгжих вэ?	14
4	Нэмэлт мэдээлэл.....	15
4.1	Төслийн талаарх нэмэлт мэдээллийг хаанаас авч болох вэ?.....	15
4.2	Санал, гомдлоо хэрхэн гаргах вэ?.....	15
5	Хавсралт	16

1 Удиртгал

Энэхүү техникийн бус хураангуйд (ТБХ) Монгол Улсын Дорноговь аймгийн Сайншанд салхин парк төслийн (цаашид Төсөл гэх) талаарх товч мэдээлэл, төслийн ашиг тус, байгаль орчин-нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар тусгасан. Энэ бичиг баримтад тусгагдсан мэдээлэл нь 2015 онд “Байгаль Экологи” ХХК-ийн гүйцэтгэсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННУ), 2016 онд “Тэкол” ХХК-ийн хийсэн нэмэлт судалгаанууд болон бие даасан зөвлөхүүдийн төслийн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлийн зөвлөмж зэрэгт тулгуурласан.

1.1 Төсөл гэж юу вэ?

Төсөл гэдэг нь 25 салхин цахилгаан үүсгүүрээс (СЦҮ) бүрдэх 54 мегаватт (МВт) хүчин чадал бүхий салхинаас эрчим хүч гарган авах салхин парк юм. СЦҮ-үүдийг газарт суулгах бөгөөд тэдгээрээс үүсгэсэн эрчим хүчийг газар доорх цахилгаан шугам сүлжээгээр дамжуулан цахилгааны дэд станц руу шилжүүлнэ. Эндээс цахилгааныг Сайншанд хотод баригдах 110/35 киловольтын хүчин чадал бүхий трансформатор руу 8 км урттай цахилгаан дамжуулах агаарын шугамаар дамжуулах ба тэндээсээ эрчим хүчний төв сүлжээнд цахилгаанаа нийлүүлнэ. Төслийн үйл ажиллагаанд зориулан төслийн талбайд дотоод ашиглалтын замын сүлжээг бий болгоно.

Төслийн барилгын үйл ажиллагаа нь 2017 оны 2-р улирлаас эхлэхээр төлөвлөж байгаа бөгөөд эрчим хүчээ 2019 оноос эхлэн үйлдвэрлэнэ.


1.2 Төслийг хэрэгжүүлэгч нь хэн бэ?

ХБНГУ-ын Ферростаал, Энжи болон бусад ижил эрхт хөрөнгө оруулагчдын үүсгэн байгуулсан Сайншанд салхин парк ХХК нь төслийг хэрэгжүүлэгч юм.

1.3 Төсөл хаана хэрэгжих вэ?


Төсөл нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотоос зүүн урд зүгт 460 км зайд орших Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын уулзвар нутаг, Улаан толгойн хөндий гэх газарт хэрэгжинэ. Төсөл хэрэгжих газар нутаг нь ерөнхийдөө цөлөрхөг хээрийн шинжтэй, ургамлан нөмрөг маш сийрэг ургадаг. Хамгийн ойрын суурин газар нь Сайншанд хот бөгөөд төслийн талбай нь баруун хойд зүгт 15 км оршино. Малчид малаа улирлын шинжтэй бэлчээрлүүлдэг бөгөөд төслийн талбай орчим дахь өвөлжөө, гар худгуудыг ашигладаг. Төслийн талбай нь төрийн өмч бөгөөд холбогдох хууль тогтоомжийн дагуу “Сайншанд салхин парк” ХХК эзэмшиж байна. Төслийн талбайн байршлыг Зураг 1, төслийн ерөнхий зохион байгуулалтыг Зураг 2-д үзүүлэв.

Зураг 1: Сайншанд салхин парк төслийн байршил



Эх үүсвэр: Байгаль орчны төлөв байдлын судалгаа, 2014

Зураг 2: Төслийн ерөнхий зохион байгуулалт



Эх сурвалж: Сайншанд салхин парк төслийн БОННУ-ний тайлан, Байгаль Экологи ХХК 2015

Төслийн бүрэлдэхүүн хэсгүүд:

- ~ 25 ширхэг (одоогоор Вестас загварын 110-2.2 МВт хүчин чадал бүхий 150 метрийн өндөр СЦҮ ашиглахаар төлөвлөж байгаа ба нийт хүчин чадал нь 54 МВт)
- ~ 35/110 кВ-ын хүчин чадал бүхий дэд станц, хяналтын байр, оффис, ажилчдын байр
- ~ СЦҮ-үүдийг хооронд нь болон төслийн талбай дээр цахилгааны дэд станцыг холбосон газар дээрх цахилгааны шугам сүлжээ
- ~ Сайншанд хотод баригдах 110/35 киловольтын хүчин чадал бүхий трансформатор руу 8 км урттай цахилгаан дамжуулах агаарын хос шугам
- ~ Төслийн талбайд дотоод ашиглалтын замын сүлжээ

1.4 СЦҮ болон бусад материалыг хэрхэн тээвэрлэх вэ?


СЦҮ-ийн бүх эд ангийг БНХАУ-аас ачааны тэргээр тээвэрлэх бөгөөд сэнсний цамхгуудыг БНХАУ-ын Бугат хотоос Эрэн хот хүртэл 660 км зайд, бусад хэсгийг БНХАУ-ын Тяньжин хотоос Эрэн хот хүртэл 830 км зайд тээвэрлэн, Монгол Улсын Замын-Үүдийн хилийн боомтоор орж ирсэн тоног төхөөрөмжийг Сайншанд хүртэл 232 км зайд хатуу хучилттай замаар, Сайншанд хотын орчимд хатуу хучилттай замаас салж төслийн талбай хүртэл 4 км сайжруулсан шороон замаар тээвэрлэнэ.

Төслийн дотоод ашиглалтын замын сүлжээг бий болгоно.

1.5 СЦҮ нь эрчим хүчийг хэрхэн гаргадаг вэ?

СЦҮ нь сэнс, хурдны хайрцаг, цамхаг гэсэн гол хэсгүүдээс бүрдэнэ. Байгалийн салхины үйлчлэлээр сэнс эргэлдэж, хурдны хайрцаг ажиллана. Хурдны хайрцгийн эргэлдэх хөдөлгөөнөөр соронзон орон үүсэж, тэр нь цахилгааныг үйлдвэрлэнэ. Цахилгаан нь трансформаторын тусламжтайгаар тогтмол гүйдэлд шилжиж, тэр нь эрчим хүчний сүлжээнд нийлүүлэгдэнэ. Зураг 3-д СЦҮ-ийн бүтцийг харуулав.

Зураг 3: СЦҮ-ийн бүтэц



Эх сурвалж: <http://www.gov.scot/Resource/Img/150324/0044577.jpg>

2 Төслийн үндэслэл

2.1 Энэ төсөл яагаад хэрэгтэй вэ?

Монгол Улс хүлэмжийн хийг багасгах, салхины, нарны, газрын гүний, усны эрчим хүч зэрэг сэргээгдэх эх үүсвэрээс эрчим хүч үйлдвэрлэхийг дэмжсэн бодлого боловсруулсан. Төрөөс баримталж буй бодлогын хүрээнд 2020 он гэхэд үндэсний эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 20-25% сэргээгдэх эрчим хүчээр хангахаар зорьж байна.

Энэхүү төсөл нь Монгол Улсын өмнөө тавьж буй дээрх зорилгыг хангахад хувь нэмрээ оруулахын зэрэгцээ өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэгцээг хангах, сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй улбаатай байгаль орчны өөрчлөлтийг саармагжуулахад хувь нэмрээ оруулна.

Салхины эрчим хүч нь сэргээгдэх эх үүсвэрт тооцогдох бөгөөд нүүрс, байгалийн хийгээр ажиллаж эрчим хүч үйлдвэрлэдэг уламжлалт аргуудын хажууд эрчим хүч үйлдвэрлэлийн тогтвортой эх үүсвэрт зүй ёсоор тооцогдоно. Түүнчлэн салхин цахилган станц нь агаарын чанар, усны чанарт сөргөөр нөлөөлөхгүй, хүлэмжийн хийг ялгаруулдаггүйгээрээ байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл юм. Гэвч зарим нэг талаараа байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үзүүлэх бөгөөд энэ талаар 3-р бүлэгт дурдсан. Эдгээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах бүрэн боломжтой.

2.2 Төслийн ашиг тус юунд орших вэ?

Төслийн төлөвлөлтөөс үзвэл эрчим хүчийг сэргээгдэх эх үүсвэрээс гаргах бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийг хөдөлгөгч хүчин зүйл болох хүлэмжийг хийг ялгаруулахгүй гэдгээрээ байгаль орчинд ашиг тустай. Төслийн хүчин чадалтай тэнцүү хэмжээний эрчим хүчийг нүүрснээс гарган авах бол нэг жилд ялгарах нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээг 182 мянган тонноор¹ болон 437 тонноор² нэмэгдүүлэхээр байсан. Тиймээс Монгол Улсын нийт эрчим хүч үйлдвэрлэлээс дээрх хэмжээний нүүрсхүчлийн давхар ислийг ялгаруулахгүй байна гэсэн үг юм.

Үүнээс гадна, орон нутгийн түвшинд дараах ашиг тусыг үзүүлнэ. Үүнд:

- ~ Нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцаас ялгарах бусад бохирдуулагчдын хэмжээг багасгах
- ~ Ажлын байрыг бий болгох
- ~ Татвар болон цалингийн тогтолцоогоор дамжин орон нутгийн орлого өсөх

2.3 Ямар хувилбарууд байж болох вэ?

Төрөөс баримталж буй бодлогын хүрээнд 2020 он гэхэд үндэсний эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 20-25% сэргээгдэх эрчим хүчээр хангахаар зорьж байгаа тул “төсөл хэрэгжүүлэхгүй” гэсэн хувилбарыг авч үзээгүй.

Төслийн ерөнхий зохион байгуулалтыг гаргахдаа техникийн шаардлагыг хангахын зэрэгцээ байгаль орчин, хүний эрүүл мэнд, аюулгүй байдлыг харгалзан үзсэн. Төслийн бэлтгэл үе шатны явцад Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам болон орон нутгийн захиргаад төслийн үйл ажиллагаа нь байгаль орчны шаардлагуудыг хангасан гэж дүгнэсэн.

¹ ОУСК-ийн дулааны цахилгаан станцын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зааварчилгаа

² Олон улсын эрчим хүчний агентлагийн тооцоолсон түлшний шаталтаас үүсэх нүүрсхүчлийн давхар ислийн хэмжээ, 2016

Төслийн дэд бүтэц, СЦҮ-үүдийн байршил, дотоод зам, ажилчдын байр, цахилган дамжуулах шугам зэрэг нь мөн л байгаль орчин, нийгмийн талаас сөрөг нөлөө хамгийн багатай байх хувилбаруудыг боловсруулж, одоогийн сонголтыг хийсэн.

2.4 Байгаль орчин-нийгмийн нөлөөллийн үнэлгээ гэж юу вэ?

2015 онд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг үндэсний хууль тогтоомжийн дагуу хийсний дараа олон улсын санхүүжүүлэгч байгууллагуудын шаардлагын дагуу нарийвчилсан судалгаа, үнэлгээг гүйцэтгэсэн. Үүнд төслийн дэд бүтэцтэй уялдсан байгаль орчин-нийгмийн болзошгүй нөлөөллийн үнэлгээ, нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө болон биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөө зэрэг нь багтана.

Дээрх үнэлгээнүүдээс гадна Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 2014 онд баталсан Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу болон дор дурдсан бусад олон улсын байгууллагуудын стандартын дагуу байгаль орчин, нийгмийн иж бүрэн судалгаа, үнэлгээг хийсэн. Үүнд:

- ~ Олон улсын санхүүгийн корпорацийн гүйцэтгэлийн шалгуур 2012
- ~ Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн зөвлөмж 2007
- ~ Цахилгаан шугам сүлжээ, түгээлтэд зориулсан Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн зөвлөмж 2007
- ~ Салхины эрчим хүчид зориулсан Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн зөвлөмж 2007
- ~ Европын хөрөнгө оруулалтын банкны Байгаль орчин, нийгмийн стандарт 2013
- ~ Европын хөрөнгө оруулалтын банкны биологийн олон янз байдал ба экосистемийн стандарт 2013

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны 2014 онд баталсан Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу уг төсөл нь “В” ангилалд хамаарах ба энэ нь төсөл хэрэгжиж буй газар орчимдоо байгаль орчин-нийгмийн сөрөг нөлөөллийг үзүүлж болзошгүй ба түүнийг бууруулах боломжтой гэж үздэг.

2.5 Зөвлөгөөн ба мэдээлэл түгээлт

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад сумын захиргаа, Сайншанд сумын өрхүүд болон малчдад мэдээлэл түгээхийн зэрэгцээ зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулсан. Мөн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын иргэдтэй байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний талаар хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан.

Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөг боловсруулсан бөгөөд түүнд сонирхогч талуудыг тодорхойлохын зэрэгцээ тэдэнтэй зөвлөлдөх, мэдээлэл түгээх хуваарийг гаргасан.

2.6 Төслийн талбайн байгаль орчин-нийгмийн өнөөгийн төрх байдал

Сайншанд салхин парк төслийн талбай нь далайн түвшнээс дээш 1005 м өндөр Улаан толгойн хөндий гэх газарт Улаанбаатар хотоос зүүн урагш 460 км, Замын-Үүд дэх хилийн боомтоос баруун хойд зүгт 220 км, Сайншанд сумын төвөөс зүүн урд зүгт 5 км зайд Дорноговь аймгийн Сайншанд сумын 3-р баг, Өргөн сумын 1-р баг, Алтанширээ сумын 3-р багийн нутаг, өөрөөр хэлбэл 3 багийн хийлийн зааг нутагт оршино.

Төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй одоогийн талбай нь Дорноговь аймгийн Сайншанд, Өргөн, Алтанширээ сумдын хилийн зааг нутагт байрлаж, газар ашиглах эрхийг 3 сумын захиргаа тус бүрээс авсан бөгөөд нийт 486.6 га талбайг 30 жилийн хугацаатай ашиглуулах шийдвэр гаргасан байна.


Төслийн талбай нь тэгш хавтгай бөгөөд урд талдаа дов толгодтой. СЦҮ-үүд нь тэгш өндөрлөг газарт баруунаас зүүн тийшээ чиглэн шугаман байдлаар суурилагдана. Төслийн талбайд ургамлан нөмрөг сийрэг бөгөөд бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байна. Төслийн талбайд модлог ургамал байхгүй ба урд зүгт ойролцоогоор 1 км орчим зайд хэд хэдэн хайлаас тааралдана.

Төслийн талбай орчмын 5 км зайд суурьшлын бүс байхгүй. Хамгийн ойрын суурин газар болох Сайншанд хот нь төслийн талбайгаас баруун хойд зүгт 7 км зайд байрлана. Төслийн талбай орчимд бэлчээрийн мал аж ахуй бүхий цөөн малчин өрхүүд амьдрах ба гар худаг, өвөлжөөтэй.

Төслийн талбайд тусгай хамгаалалтад авсан газар нутаг байхгүй, археологи, палеонтологийн чухал газрууд тэмдэглэгдээгүй. Сайншанд салхин парк төслийн талбай нь Зоогийн хоолой хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс 8-9 км зайд оршиж байгаа нь төсөл хэрэгжих газарт хамгийн ойр байршилтай хамгаалалттай газар юм.

Төслийн талбайн ерөнхий төрхийн Зураг 4-д үзүүлэв.

Зураг 3: Сайншанд салхин паркийн газрын зураг



Эх сурвалж: Сайншанд салхин парк төслийн БОННУ-ний тайлан, Байгаль Экологи ХХК 2015

3 Төслийн байгаль орчин-нийгмийн болзошгүй эерэг ба сөрөг нөлөөлөл

3.1 Ерөнхий мэдээлэл

Дараах хүснэгтэд төслийн барилгын болон үйл ажиллагааны үеийн байгаль орчин-нийгмийн эерэг ба сөрөг нөлөөллүүдийг тодорхойлсон бөгөөд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах болон эерэг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг төлөвлөсөн.

Хүснэгт 1: Төслийн байгаль орчин-нийгмийн нөлөөлөл

Байгаль орчин, нийгмийн бүрэлдэхүүн	Нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ
Ландшафт ба харагдах байдал	
Нөлөөлөл	Төслийн талбайн ойр орчимд амьдарч буй хүмүүст орчны харагдах байдлын нөлөөлөл үзүүлнэ.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Төслийн талбай нь газрын төрх байдлын хувьд бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байгаа, тусгайлан хамгаалагдаагүй. СЦҮ нь одоогийн харагдаж байгаа өөрчлөх бөгөөд түүнийг бууруулах боломж хязгаарлагдмал. СЦҮ нь төсөл хэрэгжих хугацаанд ландшафтын бүрэлдэхүүн хэсгийн нэг болох бөгөөд орчны оршин суугчдад харагдах байдлын нөлөөлөл үзүүлнэ. Төслийн талбай орчим байрлаж буй зарим малчин өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх бөгөөд эдгээр өрхийн хүн амын харагдах байдлын нөлөөлөл буурна.
Дуу чимээ	
Нөлөөлөл	Төслийн талбайн ойр орчимд суурьших хүн амд дуу чимээ нөлөөлөл үзүүлнэ.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Дуу чимээний үнэлгээ хийгдсэн бөгөөд СЦҮ-ээс 500 метрийн аюулгүй зайг тогтоосноор дуу чимээний эрсдэлийг бууруулна. Аюулгүй зайны гадна амьдрах хүмүүст үзүүлэх дуу чимээний нөлөөлөл үндэсний болон олон улсын зөвшөөрөгдөх хэмжээнд байна. Төслийн барилгын ажлын болон үйл ажиллагааны үеийн дуу чимээг бууруулах сайн практик туршлагыг хэрэгжүүлнэ. Үйл ажиллагааны үеийн дуу чимээг байнга хянах ба үндэсний болон олон улсын зөвшөөрөгдөх хэмжээнд байлгана.
Экологи ба байгаль хамгаалал	
Тусгай хамгаалалттай газар нутаг	Төслийн талбайд тусгай хамгаалалтад авсан газар нутаг байхгүй, археологи, палеонтологийн чухал газрууд тэмдэглэгдээгүй. Сайншанд салхин парк төслийн талбай нь Зоогийн хоолой хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс 8-9 км зайд оршиж байгаа нь төсөл хэрэгжих газарт хамгийн ойр байршилтай хамгаалалттай газар байна.
Амьдрах орчин ба ургамал	Төслийн талбай нь Зүүн Говийн цөлөрхөг хээрийн эко бүсэд байрлана. Талбай нь ихэнх хэсэг нь мал идээшлэл болон замбараагүй замын хөдөлгөөнөөс улбаалан бэлчээр нь доройтсон. Талбайн зүүн хойд хэсэг нь хүний нөлөөнд харьцангуй бага өртсөн, байгалийн төрхөө хадгалсан байна. Төслийн талбай орчмоос нийт 36 зүйл ургамал тодорхойлогдсоноос Дэлхийн байгаль хамгаалах хорооны ургамлын ховордлын зэргийн улаан жагсаалтаар эмзэг гэж ангилагдсан Хойрог харгана олдсон. Төслийн гол нөлөөлөл нь СЦҮ болон бусад барилга байгууламжтай холбоотой амьдрах орчин алдарна. Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөө боловсрогдож, төслийн бүхий л хугацаанд сөрөг нөлөөллийг бууруулах болон хяналт тавих тогтолцоог бий болгосон. Төсөл хэрэгжихээс өмнө доройтолд өртсөн байсан газруудыг нөхөн сэргэх ажил тусгагдаагүй.

**Байгаль орчин,
нийгмийн бүрэлдэхүүн**

Нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ

Амьтан	Төслийн талбай орчимд хоёр зүйлийн ховордож буй амьтан олдсон бөгөөд нэг нь Монголын амьтны улаан жагсаалтаар нэн ховор гэж бүртгэгдсэн цагаан зээр, нөгөө нь Монгол амьтны улаан жагсаалт ба Дэлхийн байгаль хамгаалах хорооны амьтны ховордлын зэргийн улаан жагсаалтаар эмзэг гэж ангилагдсан хар сүүлт зээр юм. Төслийн талбай орчимд бусад жижиг мэргэчид болон мөлхөгчид амьдардаг. Төслийн барилгын ажлын явцад дээрх зээрүүдийн нүүдлийн замд бага зэргийн садаа учруулах боловч нүүдлийн гол замаас алслагдсан тул сөрөг нөлөөгүй гэж үзэв. Төслийн талбайг нэлэнхийд нь хашаалахгүй бөгөөд зөвхөн аюулгүй ажиллагааны үүднээс дэд станцыг хашаалах тул аливаа амьтны нүүдэлд садаа учруулахгүй. Барилгын ажил зарим мэргэчид болон мөлхөгчдийн амьдрах орчныг сүйтгэх болзошгүй тул шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэлтийг хийнэ.
Сарьсан багваахай	Хоёр төрлийн сарьсан багваахай (Буурал сармаахай, Азийн буурал сармаахай) төслийн талбай орчимд олдсон бөгөөд хоёулаа Монголын амьтны улаан жагсаалт ба Дэлхийн байгаль хамгаалах хорооны амьтны ховордлын зэргийн улаан жагсаалтаар элбэг буюу анхаарал өртөхөөргүй гэж ангилагдсан байна. Төслийн талбайд сарьсан багваахайн үүр олодоогүй бөгөөд харин хооллосон ул мөр илэрсэн. Төслийн үйл ажиллагаанаас сарьсан багваахайд СЦҮ-ийн сэнсэнд өртөх болон шөнийн цагт гэрлийн улмаас зүг чигээ алдаж болзошгүй. Сарьсан багваахайд хүчтэй нөлөөлөл байхгүй бөгөөд төслийн үйл ажиллагааны турш мониторинг хийгдэнэ. Шөнийн цагт гадаад гэрэлтүүлгийг бага ашиглана.
Шувуу	СЦҮ болон цахилган дамжуулах агаарын шугамын дагуу Монгол Улсын шувуудын улаан жагсаалтаар эмзэг, Дэлхийн байгаль хамгаалах хорооны шувуудын ховордлын зэргийн улаан жагсаалтаар ховордсон Идлэг шонхор, Монгол Улсын шувуудын улаан жагсаалтаар элбэг, Дэлхийн байгаль хамгаалах хорооны шувуудын ховордлын зэргийн улаан жагсаалтаар ховордсон Талын бүргэд амьдардаг нь тогтоогдсон. Дээрх шувуудад учрах эрсдэлийг бууруулахын тулд цахилган дамжуулах агаарын шугамд үргээгч байрлуулах, төслийн талбай болон түүний ойр орчим дахь амьтны сэгийг зайлуулж шувуудын сэгэр хооллох боломжийг хязгаарлах, хиймэл үүрийг төслийн талбайгаас хол байгуулах зэрэг багтана. СЦҮ болон бусад барилга байгууламжийг барих үед газарт үүрлэдэг шувуудыг устгах эрсдэлтэй. Төслийн барилгын ажлын өмнө газрын үүр бий эсэхийг нягтлан шалгаж, шувуудын үржлийн үеийн өмнө тухайн хэсгийн ургамлан нөмрөгийг цэвэрлэх шаардлагатай.

Замын хөдөлгөөн ба тээвэрлэлт	
Нөлөөлөл	Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нэмэгдэх ба барилгын ажлын үеийн хүнд даацын тээврийн хэрэгсэл нь орон нутгийн замыг эвдлэх эрсдэлтэй.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Барилгын үеийн авто тээврийн хөдөлгөөн богино хугацаанд улирлын шинжтэй үргэлжлэх бөгөөд нөлөөлөл нь богино хугацаанд байна. Хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний үед зам эвдрэх магадлалтай ба ингэсэн тохиолдолд засвар үйлчилгээг байнга хийнэ. Авто тээврийн хөдөлгөөнөөс үүсэх нөлөөллийг дараах байдлаар бууруулна. Үүнд: ~ Барилгын ажлын үеийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг орон нутгийн холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр ард иргэд, байгаль орчинд хамгийн бага нөлөөтэй замналыг сонгоно. ~ СЦҮ-үүдийг зөөвөрлөх замыг тусгайлан засаж сайжруулах ба энэ нь ирээдүйд олон нийтэд ашиглагдана. ~ Үйл ажиллагааг замын хөдөлгөөн хамгийн бага байх түвшинд зохион байгуулна.

Байгаль орчин, Нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ нийгмийн бүрэлдэхүүн

Сүүдэрлэлт

Нөлөөлөл	СЦҮ-ийн эргэлдэж буй сэнс нь сүүдэрлэлтийн нөлөөг үзүүлнэ.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Сүүдэрлэлтийн нөлөөллийн үнэлгээгээр төслийн талбай орчимд амьдарч буй малчдад сүүдэрлэлтийн нөлөө үзүүлж болзошгүй гэж дүгнэгдсэн. Иймд СЦҮ-ээс 500 метрийн зайд аюулгүйн бүсийн татаж, үүн дотор хүн тогтмол амьдрахыг хориглосноор сүүдэрлэлтээс үүсэх эрсдэлийг бууруулна. Хэрвээ ямар нэгэн байдлаар сүүдэрлэлтийн нөлөөлөлд өртсөн гэж үзвэл олон нийтийн санал, гомдлыг хүлээн авах механизмын дагуу өртөгчийн тодорхойлж, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг авна.

Археологи

Нөлөөлөл	Барилгын ажил нь археологийн олдворыг сүйтгэж болзошгүй.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Төслийн талбай нь соёлын өв болон тусгай хамгаалалтад авагдаагүй тул археологийн болон соёлын өвийн аливаа үнэт зүйлд шууд үзүүлэх нөлөөлөл байхгүй. Төслийн талбайд тусгай хамгаалалтад авсан газар нутаг байхгүй, археологи, палеонтологийн чухал газрууд тэмдэглэгдээгүй. Сайншанд салхин парк төслийн талбай нь Зоогийн хоолой хэмээх орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн хилээс 8-9 км зайд оршиж байгаа нь төсөл хэрэгжих газарт хамгийн ойр байршилтай хамгаалалттай газар байна. Урд зүгт 230 метр орчимд орших толгодын дээд талд овоо байрлах ба түүнийг төслийн явцад хамгаалж, аливаа шууд нөлөөлөлд өртүүлэхгүй. Гэвч газар шорооны ажлын явцад өмнө нь илрүүлээгүй археологийн аливаа олдвор олдох магадлалтай тул энэ үед ажиллах процессыг боловсруулсан. Үүнд хэрвээ аливаа зүйл олдсон тохиолдолд төслийн үйл ажиллагааг шууд зогсоож, орон нутгийн холбогдох газарт яаралтай мэдэгдэхийн зэрэгцээ мэргэжлийн байгууллагаас аливаа арга хэмжээ авах хүртэл төслийн үйл ажиллагааг түр зогсооно. Энэ талаар ажилчдад сургалт явуулна.

Ажил эрхлэлт

Нөлөөлөл	Бүх ажилчдад ажил эрхлэлтийн шударга байх зармыг баримтална.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Барилгын ажлын үед ажиллах хүчний тоо эрс нэмэгдэнэ. Зарим ажлын байрууд тусгайлан мэдлэг, ур чадвар шаарддаг тул тусдаа гэрээлэгч нараар гүйцэтгүүлнэ.

Нийтийн эрүүл мэнд ба аюулгүй байдал

Нөлөөлөл	Орон нутгийн дэд бүтэц болон олон нийтийн аюулгүй байдалд нөлөөлөл үзүүлнэ.
Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ	Барилгын үеийн аюулгүйн төлөвлөгөө болон процессыг боловсруулан хэрэгжүүлж, барилгын ажлаас орон нутгийн ард иргэдэд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгана. Барилгын ажлын үед аюулгүй зайнуудыг тогтоож, энэ тухайгаа орон нутгийн иргэдэд сурталчлан таниулж, тэдний ухамсрыг дээшлүүлснээр эрсдэлийг бууруулна. Барилгын ажил болон яаралтай бус үйл ажиллагааг зөвхөн өдрийн цагаар явуулна. Төслийн барилгын ажлын болон үйл ажиллагааны туршид сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөөний дагуу олон нийттэй харилцаж, мэдээлэл түгээнэ. Түүнчлэн орон нутгийн ард иргэд санал, гомдол барагдуулах механизмын дагуу өөрсдийн санал бодлыг чөлөөтэй илэрхийлж болно. Жишээ: дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, хэт хурдтай давхих гэх мэт.

Газар ашиглалт, нүүлгэн шилжүүлэлт

Нөлөөлөл	Төслийн талбай болон цахилгааны шугамын дагуу амьдарч буй ард иргэдэд газар ашиглалтын талаар нөлөөлөл үзүүлнэ.
----------	---

**Байгаль орчин,
нийгмийн бүрэлдэхүүн****Нөлөөлөл ба түүнийг бууруулах арга хэмжээ**

Үнэлгээ ба бууруулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаатай холбоотой газар ашиглалтын зөвшөөрөл, гэрээнүүд хийгдсэн.

Төслийн эрсдэлийн үнэлгээгээр СЦҮ-үүдээс 500 метрийн аюулгүйн зайг татах хэрэгтэй бөгөөд ингэснээр дуу чимээ, сүүдэрлэлт, сэнс болон мөс шидэгдэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломж бүрдэнэ. Энэ аюулгүйн зайнд 2 малчин өрхийн өвөлжөө байршиж байгаа бөгөөд 3-4 малчин өрхийн зуншлагын газарт хязгаарлалт тогтооно. Эдгээрээс үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулсан бөгөөд шилжүүлэлт хийгдэх өрхүүдэд зориулан дундын эзэмшлийн гүний худаг гаргаж өгөхийн зэрэгцээ амьжиргааг дээшлүүлэх төлөвлөгөөний дагуу нөхөн төлбөр олгох, түүнчлэн бэлчээрийн хүндрэлтэй нөхцөлд эхний хоёр жил малын гэжээлээр хангана.

Хуримтлагдах нөлөөлөл

Орон зай, цаг хугацааны хувьд ойролцоо хэрэгжих бусад төслүүдээс улбаатай төслийн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр энэ төрлийн нөлөөлөлгүй гэж үзсэн. Хэрвээ байгаль орчин-нийгмийн ямар нэгэн нэмэлт сөрөг нөлөөлөл тодорхойлогдвол түүнийг бууруулах нэмэлт арга хэмжээ төлөвлөгдөнө.

Хаалт

Төслийн үргэлжлэх хугацаа 25 жил бөгөөд төслийн хаалтын үед бүх сонирхогч талууд зөвшилцөж, төслийг цаашид үргэлжлүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Төслийн барилга байгууламж, үйл ажиллагаанд өртсөн газар нутаг, экосистемийг нөхөн сэргээх нь хамгийн чухал үйл ажиллагаа байна.

Төслийн хаалтын үед аливаа ашиглагдаж байсан, цаашид үргэлжлүүлэн ашиглах боломжгүй бараа материал, байгууламжийг төслийн талбайгаас зайлуулж, байгаль орчин-нийгэмд халгүй байдлаар устгана.

3.2 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрхэн хэрэгжих вэ?

Төслийн туршид сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхийн тулд байгаль орчин-нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон олон нийт, оролцогч талуудтай зөвшилцсөний үндсэн дээр байгаль орчин-нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

Байгаль орчин-нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөө нь төслийн барилгын ажлын болон үйл ажиллагааны үеийн гэсэн тусдаа бие даасан байгаль орчин-нийгмийн менежментийн төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжинэ. БОНМТ нь байгаль орчин-нийгмийн менежментийн системийг бүрдүүлэх бөгөөд барилгын ажлын үед барилга ажил гүйцэтгэгчээр, үйл ажиллагааны үед оператор компаниар хийгдэнэ. БОНМС нь олон улсын ISO 14001 системтэй нийцсэн байна.

Олон улсын стандарт OHSAS 18001 дагуу эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны системийг нэвтрүүлэх бөгөөд үүнд ажилчдын байрны асуудал тусгагдана.

Түүнчлэн, олон нийтийн санал, гомдлыг барагдуулах механизмыг боловсруулж, хэрэгжүүлэх бөгөөд түүндээ санал гомдлыг хэрхэн гаргах, хэн, яаж шийдвэрлэх, хариу хэрхэн мэдэгдэх гэх мэт нарийвчилсан үе шатуудыг тусгана.

Төсөл хэрэгжүүлэгч болон гэрээлэгч нар төслийн барилгын ажлын болон үйл ажиллагааны туршид төслийн талбайд байрлах байгаль орчин, эрүүл ахуй, аюулгүй байдал (БОЭААБ) болон олон нийтгүй харилцах (ОНХ) мэргэжилтнүүдийг томилж ажиллуулна.

4 НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

4.1 Төслийн талаарх нэмэлт мэдээллийг хаанаас авч болох вэ?

Сонирхогч талуудын оролцоог хангах төлөвлөгөө боловсруулж, түүндээ талуудын уулзалт зохион байгуулах, мэдээлэл түгээлт зэрэг асуудлууд тусгана. Тус төлөвлөгөөг шаардлагатай тохиолдол бүрд шинэчилж байна. Төлөвлөгөө нь дараах асуудлуудыг тусгана. Үүнд:

- ~ Сонирхогч талууд болон нөлөөлөлд өртөгчдийг тодорхойлох
- ~ Олон нийтийн зөвлөлдөх уулзалт болон мэдээлэл түгээлтийн шаардлага, хуваарь
- ~ Өмнөх уулзалтуудын талаар товч мэдээлэл
- ~ Сонирхогч талуудын оролцоог хангах арга зүй болон бололцоо
- ~ Гомдол, санал барагдуулах механизм

Олон нийттэй харилцах мэргэжилтэн төслийн талбайд байршиж ажиллах бөгөөд тус мэргэжилтэн СТОХТ-г хэрэгжүүлнэ.

Нэмэлт мэдээллийг доорх хаягаар хандан авч болно.

Харьцах мэргэжилтэн:	Д.Нандинбаяр
Орон нутаг дахь хаяг:	Төслийн талбай
УБ хот дахь хаяг:	Сайншанд салхин парк ХХК 801 тоот, DHL байр Энхтайваны өргөн чөлөө- 10/5 Сүхбаатар дүүрэг Улаанбаатар-14210 Монгол Улс
Утасны дугаар:	+976-99990416
Цахим шуудан:	nandinbayar@euro-khan.com
Цахим хаяг:	www.sainshandwindpark.mn

4.2 Санал, гомдлоо хэрхэн гаргах вэ?

Хавсралт А-д үзүүлсэн санал, гомдол хүлээн авах хуудсыг бөглөж, энгийн болон цахим шуудангаар олон нийттэй харилцах мэргэжилтэнд илгээнэ. Мөн утсаар харилцах боломжтой.

5 Хавсралт

Олон нийтийн санал, гомдол хүлээн авах маягт

Би, (овог, нэр)	
Оршин суугаа хаяг:	
Утас:	Цахим шуудан:
Дараах санал, гомдлыг (байршил болон хугацааг заана) гаргаж байна.	
Асуудлыг шийдвэрлэх санал:	
Холбоо тогтоох арга зам: (яриа: <input type="checkbox"/> уулзалт, <input type="checkbox"/> утас; бичгээр: <input type="checkbox"/> цахим шуудан, <input type="checkbox"/> чат):	
Гарын үсэг:	Огноо:
.....